

# Мэдээллийн самбар - 3.

## Ой хамгаалал

Монголын ойд хүний үйл ажиллагаа ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ?

- хэт том талбайд мод бэлтгэх
- хууль бус мод бэлтгэл / санаатай
- ойрхон давтамжтай өргөн цар хүрээтэй ойн түймэр
- алт олборлолтоос үүдэн бэлчээрийн талбай хорогдох
- бэлчээр хорогдсоноос малын бэлчээр ойруу тэлэх



Хорхой шавж болон өөр ан амьтан ч ойд хөнөөл учруулдаг байх нээ.

Гол биотик хөнөөгч – шавж (хүр хорхой, хүр эрвээхий)

Нарс модыг гэмтээгч хөнөөлт шавж

### Хүр хорхой (*Ips subelongatus*)

Хүр хорхой авгалдайгаа өвчтэй модонд шахдаг бөгөөд модонд учруулах хөнөөл нь тийм ч аюултай бус юм. Харин хэт их олширсон тохиолдолд модыг бөөнөөр нь гэмтээдэг бөгөөд үүнээс болж мод хатаж хорчийдог. Мод бэлтгэлээс үлдсэн хаягдлыг цэвэрлэж зайлуулаагүйгээс хүр хорхой үржих нөхцөл бүрддэг.

### Сибирийн хүр эрвээхий (*Dendrolimus sibiricus*)

Сибирийн хүр эрвээхий олширсон тохиолдолд ойн талбайд их хэмжээний хохирол учруулдаг.

Мал, ан амьтны учруулдаг хохирол

Ойн экосистемд учруулж байгаа ан амьтны хохирол төдийлөн их биш ч байгалийн аясаар залуужиж байгаа өсвөрийн ургацыг гэмтээснээр их хэмжээний хохирол үүсдэг.

Бэлчээрийн тэлэлтийн эсрэг авах арга хэмжээ:

### Бэлчээрийг тойруулан хашаа хатгах

Өргөст торон болон хашаа хатгаснаар ойг малын бэлчээрээс тусгаарлаж өгдөг бөгөөд мал аж ахуй хөгжсөн орнуудад энэ аргыг хэрэглэж байгаа нь санхүүгийн болон хашаа угсралтын хувьд боломжийн байдаг. Монгол Улсад газар тариалангийн ургацыг хамгаалах зорилгоор энэ аргыг хэрэглэдэг.

### Зулзага мод болон өсвөрийн ургацыг тойруулан хайс хатгаж хамгаалах

Байгалийн аясаар эргэж сэргэдэг зулзаган модыг хамгаалах зорилгоор ашигладаг. Ариг гамтай хэрэглэсэн тохиолдолд дахин ашиглах боломжтой. Монгол Улсад ашиглаж байгаа хоёр төрлийн хайсны зураг.

### Модонд түрхэх цацлаганы төрөл

Хайс барихад тохиромжгүй тохиолдолд ж нь: эгц налуу газарт ургаж байгаа модонд цацлага түрхдэг. Үүргэвчин шүршигчээр шүрших эсхүл сойзоор түрхлэг хийдэг.

Мөөгөнцрөөс үүсдэг хохирол

Модны их бие түймэрт идэгдэж гэмтсэнээр мөөгөнцөр үржих таатай нөхцөл бүрддэг. Мөөгөнцөрт идэгдсэн мод яваандаа ялзарч техникийн ашиглалт нь буурдаг.



Ойг хамгаалах заавал шаардлагатай



Хог ургамал тарьц, суулгацыг гэмтээх

Шигүү ургасан хог ургамал намар хатаж, өвөл цасан бүрхүүлд хучигдсанаар нялх тарьц, суулгацыг дарж ойг нөхөн сэргээх ажилд их хэмжээний алдагдал учруулдаг. Тарьц, суулгацаа үхүүлэхгүйн тулд тогтмол арчилж эргэн тойрных нь хог ургамлыг хадах шаардлагатай. Бүлгээр нь огтолсон талбайд хог ургамлын төрөл, өтгөрөлтөөс хамаарч бургас огтлогч төхөөрөмж ашиглах нь тохиромжтой. 7 сарын сүүл 8 сарын эхээр хог ургамлыг хадахад тохиромжтой байдаг. Хог ургамлыг хадах ажил ямар нэг хохиролгүй явагдахад Тарьц, суулгацыг ижил зайтай эгнүүлж тарих нь хог ургамлыг хадах ажилд элдэв бэрхшээл үүсэхгүй сайн талтай.

Домогт Шарын Гол ойн нэгдлийн ойн эзэмшлийн талбайд хийсэн ойжуулалтын ажлын үр дүн

	нийт			нийт	%
	< 0,5	0,51-1,0	> 1,0		
эрүүд	35	46	23	104	58,10
идүүсэн	41	13	2	56	31,28
малтаж төнхсөн	1	4	5	10	5,59
хугарсан	0	0	0	0	0,00
устсан	4	2	1	7	3,91
хусуур	2	0	0	2	1,12
нийт	83	65	31	179	1,79
эгнээний тоо					
эгнээнд суулгасан суулгацын тоо					
Суулгацын анхны тоо ширхэг	1590			11,26	



Тарьц, суулгацад мал, ан амьтны учруулсан хохирол

### Аргачлал:

Ойтой ойрхон малтай айл байх нь ойн мод, сөөгөнд шууд нөлөөлж байгаа хээрийн судалгааны ажлын үр дүн харуулж байна. Нэг айл гэхэд л хонь, ямаа, үхэр, адуу нийлсэн 2000 шахуу толгой малтай байх жишээтэй. Малын ойд учруулж байгаа хохирлын зэрэглэлийг тогтоохын тулд малтай айлд ойрхон газарт туршилтын талбай хатгасан.

- 20x20 м хэмжээтэй туршилтын талбай (transekt)
- Түнхэлд - 41 туршилтын хэсэгтэй (ZP) 7 туршилтын талбай (transekt)
- Шарын голд – 23 туршилтын хэсэгтэй (ZP) 6 туршилтын талбай (transekt)

### Туршилтын талбайгаас цуглуулсан мэдээлэл:

- Туршилтын талбайн тодорхойлолт
- Мод сөөг
- Эрүүд, идүүсэн, малтаж төнхсөн, хугарсан, устсан
- Өндрийн ангилал: < 0,5 м 0,51-1,0 м, > 1,0 м
- Малын баас: үхэр, адуу, бог мал, зэрлэг амьтан
- Бусад хохирол, түймэр
- Малтай айл, малын бөөгнөрөл ихтэй газрууд

Туршилтын талбай – мал учруулсан хохирол

